

УРТЫН ДУУНЫ ХУВИЛБАР БА УЛАМЖЛАЛТ СУРГАЛТЫН ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛД

Э.Мандалт, магистр, ӨМБИС

Abstract

When are the long songs born? At moment of joy, or the sadness? Why would one get more and more fond of the long song with passage of time and with more years earned? Who possesses the wisdom to console the entire world by singing the Sun Over the Placid World. What roams in the mind of a rider who gallops all day long in the endless steppe during winter cold and summer heat? The long-song existed in the form of the abbreviated long song of today since the times of the Xingnu Empire and only later during the medieval era the long song has grown and evolved into the classical form of today. It can be demonstrated by the emergence of the well known form of long songs of today, which is the perfected and unique form of the astounding rhythmic long song. There are some cultures that have songs that bear some semblance to the long song, but they are closer to the abbreviated long song or folk songs than a genuine long-song. It can be a proof that the Long Song is an art that is unique only the Mongolia. Although the long-song is called a form of song art, it does not coincide with worldwide acknowledged description of what a song is which is why the long song, a wholly singular form of art can be said to have achieved a different and greater form of musical art. This is the reason why many scholar consider the long song to be a unique and great phenomenon in the scope of the world arts. As great songs can only be sung by great singers the long song gave birth to many great and wondrous singers.

Түлхүүр үг

Язгуур хөгжим, ардын урлаг, уртын дуу, шавь сургалт, уртын дууны хувилбар

Удиртгал

Бид энэхүү өгүүлэлдээ уртын дууны хувилбар, түүнийг өвлүүлж буй асуудлыг судлан шинжлэх зорилгоор бичсэн бөгөөд уртын дууг судлах аргазүй, туршлагыг тодруулахын зэрэгцээ судалгааны ажлын зарим үр дүнг танилцуулахыг зорилоо. Уртын дууны хувилбар, түүнийг хэрхэн заан сургаж, хэрхэн өвлүүлж буй асуудлаар судалгаа хийх нь Монгол ардын уртын дууны судалгаанд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна. Өнөөг хүртэл уртын дууны төрөл зүйл гарал үүсэл, дуулах дэг ёс, хөгжим судлал зэрэг олон талын судалгаа хийгдсээр ирсэн боловч уртын дуу нь он цагийн явцад уг эхээсээ хэрхэн хувиран бидний үед уламжлагдан ирсэн асуудлыг судлах нь зүйтэй хэмээн үзсэний үндсэн дээр боржгин халх, баянбараат, хотгойд, зүүн халх, төв халх, баруун халхын уртын дууны өвийн жишээгээр уг асуудлыг судалсан болно. Төв болон баруун, зүүн монголын айзам уртын дууны дуулах аргазүйн нөлөө бие биедээ тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байдаг нь нүүдлийн аж ахуй эрхэлдэг онцлог байдалтай холбон тайлбарлаж болмоор санагдана. Түүнчлэн цаг хугацаа орон зайн нөлөөгөөр уртын дуу хэрхэн хувирч ирсэн асуудлыг уртын дуу дуулах дэг барилын онцлогоор нь жишээ болгон өгүүлэв.

Үндсэн хэсэг

Дэлхийн хөгжмийн соёлд нүүдэлчин

Монголчуудын оруулсан чухал хувь нэмэр бол айзам хэмнэлийн хувьд “Урт” хэмээн ялган ангилсан уртын дуу билээ. Уртын дууны хэлбэр бол монголчуудын нийгэм түүхийн явцад бүрэлдсэн хөг эгшиглэгээ, аялгуу цохилго, хэллэг нугалааны бүрдмэл төгс дуурьсалтай төдийгүй бусад дуулах ур ухааны адил уужим багтаамжид агуулгатайн дээр, хөг аялгын өвөрмөц бүтэцтэйгээрээ хосгүй билээ. Малчин түмний дундаас төрсөн авьяаслаг нэгэн уртын дууг зохион дуулсан нь бидэнд уламжлагдсаар өнөөг хүрчээ. Монгол уртын дуу нь нутаг нутгийн онцлогийг хадгалсан өвөрмөц ялгааг өөртөө шингээсэн байдаг нь уртын дууны хувилбарыг бий болгоход нөлөөлсөн болов уу. Монгол уртын дуу нь нутаг нутгийн аялгууны онцлог, өөр өөрийн дуулах арга барилаар түгээмэл хэлбэрээр уламжлан дуулагдаж ирсэн олон мянган жилийн түүхтэй билээ. Уртын дуу нь гэрийн болон шавь сургалтын хэлбэрээр явагдаж иржээ.

Уртын дуу нь XII-XIII зууны үеийн Монголчуудын найр наадам, ёслолын дуу болж дэлгэрэн улмаар уртын дууны хэлбэрийг олжээ гэсэн судалгаа байдаг. Монгол гүрэн эрт үеэс хөгжмөөрөө гайхагдаж байсан агаад ордны хөгжим XIII зуунд цэцэглэн хөгжиж, Хубилай хааны ордонд олон төрлийн дуу хөгжим бий болж, агуулга нь улам баяжин, төрөл зүйл нь олширсон байдаг. Урлагийг хөгжүүлэхэд төрөөс ихээхэн

анхаарал тавьж байсан хэмээн үзэж болох талтай. Тухайлбал, XIII зуунд Их Юань гүрний Хубилай цэцэн хааны ордонд эгшиглэн дурсаж байсан их найрал хөгжмийн бүх л ёс жаяг, ёслолын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг “Их хөгжмийн яам” ажиллаж байсан нь (Чулуунцэцэг Ж, 2011, х.57) уртын дууг хэр их анхаарч хөгжүүлж байсны нотолгоо болно.

Уртын дууны хувирлын учир шалтгааныг тодруулах нь

Монгол ардын уртын дуу бол монгол ардын дууны сонгодог хэлбэр даруй мөн бөгөөд дэлхий дахины бусад үндэстэн, ястны уртын дуутай харьцуулахад урлагийн бүтээлийн шинж төлөвийн хувьд нэн өвөрмөц, гайхам сонин, давтагдашгүй урлаг хэмээн дотоод, гадаадын дуу хөгжим, урлаг судлаач нар үздэг билээ. Монгол ардын уртын дуу маш баялаг хэмнэлтэй.

Уртын дууны аялгууны олон янзын нарийн хэмнэлийг ойлгож, айзам /такт/ хуваан нотлон тэмдэглэх боломжгүй хэмээн үздэг хөгжмийн зохиолчид (Батмөнх, 2016, х.6) байна. Гэвч уртын дууны аялгууны нэгэн онцлог нь дээш цойлсон нарийн өнгөнөөс гэнэт доошилж, бүдүүн өнгөнд, бүдүүн өнгөнөөс гэнэт дээш хадааж нарийн өнгөнд маш хол үсрэн шилждэг үсрэлттэй байгаа нь мэдрэгддэг. Өөрөөр хэлбэл үндсэн дэвсгэр хөгөөсөө займарч өөр /оруулбар/ дэвсгэр хөгд шилжээд буцаж дэвсгэр хөгдөө орох зэргээр хөг солигдох нь уртын дууны аялгуунд элбэг байдаг хэмээн үзэж болно. Он цагийн уртад уртын дууны үг мөр, утга санаа өөрчлөгдөхийн зэрэгцээ үг хасагдаж, нэмэгдэж дуулагдах болсон нь ямар учир шалтгаантай болох нь сонирхол татна. Үүнд, олон зүйлийн учир шалтгаан байгаа нь гарцаагүй ч, бидний үзэхээр дор дурдсан шалтгаанууд илүүтэй нөлөөлсөн (Батболд, 2011, х.130) хэмээн үзэж байна.

- Урьд цагт уртын дууны ном судар, гар бичмэл ховор байсан бөгөөд олон түмэн бичиг үсэгт төдийлөн нэвтрээгүй байсан тэр л цагт найр наадмын газраас суралцдаг байсан тул уртын дууны үг хувирч өөрчлөгдөх гол шалтгаан болсон.
- XX зууны эхээр уртын дууг пянзанд бичиж эхэлсэн нь дэвшилттэй хэдий ч пянзны бичлэг төдийлөн тод бус байсан тул пянзнаас тухайн дууг сонсож сурч байсан дуучид, энгийн иргэд буруу, зөрүү сонссон зарим үгийг тааж дуулдаг байсан нь үг хувирах бас нэгэн шалтгаан болсон.
- Монголын нийгмийн байдал шашны нөлөөгөөр дамжин уртын дууны үг мөн хувирч ирсэн байдаг. Бурхны шашны дэлгэрлийн нөлөөгөөр бурхны шашны холбогдолтой үгнүүд уртын дуунд нэвтрэх болсноор үг хувирах бас нэгэн

шалтгаан болсон байна.

Бид уртын дууны шүлэгт нэмэгдсэн, гээгдсэн олон зүйл байгааг судалж, хойч үедээ мэдүүлж үлдээхгүй бол уртын дуугаа уг чанараар нь өвлүүлж чадахгүйд хүрнэ. Тухайлбал, Улсын үндэсний номын сангийн сан хөмрөгт ардын дууны гар бичмэл хэд хэдээр эмхэтгэж хадгалагдаж буй бөгөөд Улсын их сургуулийн багш Чойжилсүрэн 1952 онд Архангай аймгаас 300 шахам дуу бүхий эмхэтгэл, 1957 онд Өвөрхангай, Баянхонгор аймгуудаас 200 шахам дуу бүхий хоёр эмхэтгэл олж, төв номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байна. “Дөрвөдийн дууны хөх дэвтэр” хэмээх 360 дуу бүхий гар бичмэл эмхэтгэл байдаг мэдээ бий (Ринчинсамбуу, 1959, х. 4). Бидний өвөг дээдэс эртнээс уртын дууны үг, аяг аман зохиол байдлаар уламжлан ирснээс гадна бичиглэн эмхэтгэж хадгалж ирсэн баримт цөөнгүй хэдий ч нүүдлийн иргэншлийн онцлог байдлаас шалтгаалан олон гар бичмэл дайн болон нүүдлийн явцад үрэгдэж хоцорсныг дурдах нь зүйтэй болов уу.

Түүнчлэн уртын дууны ав санг сэргээх асуудлаар олон тооны судалгаа хийгдэж байгаа бөгөөд “Уртын дууны уламжлалт өв, чадварын судалгаа”-г /2008-2010/ Монгол улс, БНХАУ эрдэмтэд хамтран хийсэн бөгөөд судалгааны дүнд 100 гаруй уртын дуучдаас 200 шахам уртын дууны ая (Дорждагва М, 2013, х.9) эрэн сурвалжилж, уртын дуучдын болон уртын дууны дуу, дүрс бичлэгийн мэдээллийн сан бүрдүүлэн ажиллажээ. Судалгааны баг уртын дууны дуу, дүрс мэдээллийн санд боржгин халх, баянбараат, хотгойд, зүүн халх, төв халх, баруун халхын уртын дууны өвийг судалснаар нутаг нутгийн онцлог бүхий уртын дууны шүлэг, ая эгшиглэгээг харьцуулан судлах боломжийг уртын дуугаар судалгаа хийдэг хэн бүхэнд олгох шинэлэг судалгааг хийсэн хэмээн үзэж байна.

Тиймээс уртын дууны сургалтад уртын дууны хувилбаруудыг заахдаа тухайн орон нутгийн онцлог шинж байдал, түүхийн тухай ойлголт өгөхийн зэрэгцээ хэл шинжлэл, орон нутаг судлал, түүхийн шинжлэх ухааны уулзвар дээр судалгаа хийх нь зүйтэй. Тухайлбал, Монгол уртын дууны нутаг нутгийн аялгуунаас баянбараат аялгуу нь хэдэн онцлог ялгаатай ажээ. Судалгаанаас ажиглахад дуучны хоолой эгшгийн нам түвшинд байрлаж агаараас хийн эрчим хүч хуримтлуулахад чээжний хэнхэрцгийн булчин чөлөөтэй ажиллаж, өрцний булчингийн агшилт тэлэлтийн гүйцэтгэл төгс болдог байна. Мөн эгшиг томолтын баялаг тогтолцоо баянбараат аялгуунд элбэг байна. Монгол хэлний авиа зүйн эгшиг бүтээх арга, эгшиг сэлгэх, хувиргах зарчмууд нь баянбартаат аялгууны үндсэн хэв шинжийг бүрдүүлж байна. Боржигон аялгуу нь эгшгийн

орон зайн тэлэлтийн хувьд баянбараат аялгуунаас бага багтаамжтай бөгөөд хоолойн динамик хөдөлгөөн чимэглэлийн давтамж олонтойн дээр төвөнхийн хөндийн булчингаар болон хамрын хөндийн цуурайлгаар эрчимжүүлсэн олон төрлийн хөдөлгөөн ая (Дорждагва, 2013, х.18) хийхийг тухайн суралцагчаас шаардана. Боржигин уртын дууг сургахдаа сэтгэл хөдлөлийн хувьд сэргэлэн тэмүүлэлтэй, эрхэмсэг бардам төлөв байдлыг дуучнаас шаардана. Хөдөө орон нутагт уламжлалт шавь сургалтын арга зонхилсон гэрийн сургалт, багш шавийн холбоо тогтоох хэлбэрээр уртын дууны сургалт явагдаж байна. Эртнээс уламжилж ирсэн ардын болон уртын дуунууд хэн зохиосон мэдэгдэхгүй мөртөө хурд хэмнэл хэдийд өөрчлөгдсөн нь мэдэгдэхгүй хэдэн янзаар хувирч ирсэн нь тодорхой.

Уртын дууны уламжлалт сургалт

Зохиосон эзэн нь тэр бүр тодорхойгүй, ард түмний амнаас ам дамжин, үеэс үед уламжлагдан дуулагдаж, хувирч өөрчлөгдөж, утга агуулга нь өргөжин тэлж, шүлэг найраглалынх нь урлан улам төгөлдөржиж ирсэн (Батмөнх, 2016, х. 5) уртын дуугаа дээдлэн хүндэлж, сурч мэдэх түгээн дэлгэрүүлэх нь бидний үүрэг юм. XIX зууны сүүл XX зууны эхэн үеийн Халхын Цэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, Засагт хан аймгийн олон сайхан дуучдын хооронд багш шавийн барилдлага нягт тогтсоноор монгол уртын дууны нутаг нутгийн олон дэг сургуулийн урсгал нийлж, уртын дууны хөгжлийн шинэ үеийг нээж (Дэлгэр, 2011, х. 93) өгсөн нь уртын дууны язгуур хөгжмийн уламжлалд нэгэн дэвшилт үеийг авчирсан хэмээн үзэж болох талтай.

Монгол хөгжимчдийн талаар Ж.Бадраа "... мэргэжлийн нарийн ялгаа гараагүй байсан дээхэн үед дуучин, хөгжимчин, яруу найрагч гэж тусдаа байгаагүй ... нэг л бодгаль хүн тэдгээр мэргэжлийг бүхэлд нь эзэмшдэг цаг байжээ" (Оюунбадрах, 2013, х. 85) хэмээн онцолжээ. Уламжлалт хөгжмийг шавь сургалтаар гэрийн нөхцөлд тусгайлан зааж найр наадмын үеэр тухайн орчинд нь сургадаг байсан нь энэхүү тодорхойлолтод дурдсантай нийцэж байна. Уртын дуу дуулахын тулд дуучин хүн наад зах нь хоёр цараат хоолойтой, эмэгтэй дуучин тунгалаг, уран тунгалаг, эсхүл цөлх, тунгалаг, уран тунгалаг гурван ч цараат хоолойтой байж уртын дуу дуулдаг. (Бадраа, 2008, х. 94) хувь хүний хоолойн онцлог байдлыг харгалзан уртын дууч болох эсэхийг тодорхойлдог байна.

Ар болон өвөрмонголын уртын дууны сургалтын онцлог байдлыг харьцуулан судалгаа хийж үзвэл ижил болон ялгаатай тал олон байгааг дурдах нь зүйтэй. Гэвч өвөрмонголын

цөөнгүй газрын уртын дууг дуулах арга барил нь Монголын уртын дуутай ижил төдийгүй энэхүү ижил тал нь харьцангуй өндөр настнуудын дуулах хэв маягаас харагдаж байгаа нь түүх болон газар нутгийн онцлог байдлаас шалтгаалсан болов уу хэмээн үзэж болохоор байна. Монголын хил дагуу нутгуудад уртын дууны хувилбар илүү ижил байдлаар хадгалагдаж үлдсэн байх магадлалтай. Тухайлбал, Алаша нутгийн уртын дууны уламжлалд халх уртын дууны нөлөө харьцангуй туссан тул уртын дууны сургалтын явцад энэхүү ижил, бие бидээ харилцан нөлөөлсөн нөхцөл байдлыг нь харгалзан үзэх нь зүйтэй. Түүнчлэн Алшаа уртын дууг нутгийн өндөр настай дуучид дуулахын зэрэгцээ гэрээр шавилан сургах байдлаар өвлүүлэн хөгжүүлж байна. Тухайлбал, баруун халх, төв халх, зүүн халхын дуучдын дуулах байдлаас ажиглагддаг амны ангайлт бага, төвөнх хоолойн эрчим хүчний урсгалыг зөөлөн тагнай сөхөж хамрын хөндий, духны хөндий рүү чиглүүлж, цуурай үүсгэх, эрүүний булчингийн үйл ажиллагааг энгийн түвшинд барьж төвөнхийн хөндийн булчинг маш сайн ажиллуулж дадсан байдал ажиглагдав. Мөн залгиурын хөндийн буюу багалзуурын булчинг суллаж дууны хүчний ихэнх хувийг төвөнх, гуурсан хоолой дэх агаарын даралт, өрцний булчин, хавирга хоорондын булчингаас үүсгэж байгаа нь Халхын айзам уртын дууг дуулах арга барилыг санагдуулж байна. Үүнийг төв халх, өмнөд халхын уртын дууны хэв намба хадгалагдаж байна хэмээн ойлгож байна. (Дорждагва М, 2013, х. 20)

Түүнчлэн өвөрмонголын уртын дуунд төв болон баруун халхын боржигин чигийн дууны харилцан нөлөөлөл байгаа нь дуу дуулах хэв намбаас нь харагддаг. Мөн Өвөрмонголд "цоорын дуу" хэмээн халх ойрдын уртын дуунаас онцлог бүхий өвөрмөц нэгэн төрөл байх бөгөөд хэлний угийн хөдөлгөөнөөр дуун авиан урсгалыг үелзүүлж, эрүүний булчингийн хүчээр эгшгийн урт, богиныг нугалж, тагнайн хөндийн авиалгаар авиаг эрчимжүүлэх байдлаар дуулах чадварт сургадаг байна. Гэвч шавь сургалтын байдлаас харахад уртын дууны аялгуу нь түүхэн цаг хугацааны онцлогоос шалтгаалан байнга хувирч иржээ. Өнөө цагт хүүхдүүд дуулах сонирхолтой байгаа хэдий ч хоолойн цар нь хүрэхгүй, нэг бадаг дуулахад дунд нь дөрөв тав амьсгаа авдаг ч юм уу, тэгээд тэр завсраа өөрийнхөө өнгийг алдаад түүнээсээ болоод өөрийгөө голж, уртын дуу сурах асуудал нь замхардаг байна. Түүнчлэн уртын дуу дуулж сурахын өмнөх шат бэлтгэл болгож айзам уртын дууг дуулуулах нь их үр дүнтэй санагдана. Уртын дууг сургах анхны алхмын алтан дүрэм бол ямар ч хамаагүй уртын дууг шууд заах бус шат шатаар ур чадварыг нь ахиулахад зориулагдсан

уртын дууны ангилал хийж заах нь илүү үр дүнтэй байдаг. Уртын дуучин болох хүнд бэсрэг урт дуу “Гандан уул”, “Зээргэнтийн шил”, “Идэр жинчин”, “Хүрэн толгойн сүүдэр”, “Шалзат баахан шарга”, “Мандал жуужаа”, “Жаахан шарга” зэрэг дууг дараалан сурах хэрэгтэй. Үүнд “Мандал жуужаа”, “Дарьгангын жаахан шарга” хоёрыг дуулж сурсан хүн уртын дууны бага сургууль төгсөөд дунд ангид орлоо хэмээн ойлгож болно. Уртын дууны дунд ангийн дуу бол “Дөмөн”, “Алтан богдын шил”, “Сэрүүн сайхан хангай”, “Ар хөвч”, “Эр бор харцага” гэх мэт олон дуу бий бөгөөд дотор нь бас хүнд хөнгөнөөр нь нарийвчлан ялгаж болохын (Бадраа Ж, 2008, х. 95) зэрэгцээ тухайн суралцагчийн хоолойн өнгө цараны байдалд тохирсон дууг сургана. Тиймээс тухайн багш уртын дууны сургалт явуулахдаа эрэгтэй, эмэгтэй дуучны хоолойд ямар дуу илүү зохимжтой асуудлыг судалгаа шинжилгээний үндсэн дээр нь хоолойн цар хүрээнд нь тохируулан дуулуулж сургах нь чухал байдаг.

Уртын дуу сурахад амьсгалах эрдэмд суралцах нь чухал билээ. Амьсгалаа удаан барьж сурахын тулд “гучин хоёр цагаан лонх”, “жаран дөрвөн хул” тоолох дасгал хийдэг байжээ. Шинэ цагийн монголын хөгжмийн урлагийг үндэслэгч, монгол улсын анхны алдарт гавьяат уртын дууч, уртын дууны нэрт сурган хүмүүжүүлэгч багш М.Дугаржав “Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах тухай” өгүүлэлдээ “дуу дуулахад “ха” хэмээн хагалах энэ нь хоолой хүчлэх ажиллагаа л, ш, р эдгээр нь хэл дэвсэх, хуйлах, шүдээр хаших зэрэг ажиллагаа, м, н хэмээн хамраар гонгинох ажиллагаа, а, э, и, о, у хэмээн уруул амны хөдөлгөөнөөр гүйцэтгэх ажиллагаа, төвөнхөөр том, жижиг олон цөөн цохиж, донсолгох ажиллагаа бөгөөд энэ бүхэн нь амны зохион байгуулалтын мэдрэл хүчийг олж улмаар дууны аялгууг үүнчлэн үг эгшгийг хуваарилан мэдвэсү сая аргагүй үнэн дууны уран аялгуу нь хангалттайгаар ялгагдмуй”. (Дугаржав М, 1934, х.18) хэмээн уртын дууг дуулах ур чадвар, заах аргагүйн талаас нь тодорхой өгүүлсэн нь өнөөгийн уртын дууны сургалтад үнэ цэнээ алдаагүй ач холбогдолтой хэвээр байна.

Уртын дууны дуучин болох их, дээд сургуулийн хөтөлбөрт орох дуу бол айзам уртын дуу болох “Түмний эх”, “Дуртмал сайхан”, “Өвгөн шувуу”, “Цэвцгэр хурдан шарга”, “Замбуутивийн наран”, “Эртний сайхан”, “Уртын сайхан хүрэн”, “Эрхэм төр”, “Асрын өндөр”, “Асрын өндөр”, “Хуурын магнай”, “Хурмаст тэнгэр”, “Эрдэнийн галбарваасан мод”, “Тэгш таван хүслэн” мөн “Хэрлэнгийн баръяа”, “Их сайхан халиун” (Бадраа Ж, 2008, х. 95) зэрэг дуу юм. Айзам уртын дуу дуулснаар уртын дуу дуулаачийн дуулах чадвар улам сайжрах тул уртын дууны сургалтад айзам

уртын дууг орхигдуулж боломгүй санагдана.

Дүгнэлт

Энэхүү өгүүллийг бичсэний үндсэн дээр дараах хэдэн дүгнэлтийг хийж болохоор байна.

- Нүүдэлчин соёл иргэншил бүхий монголчууд оюуны соёлын өв сангаа биежүүлж, том том хөшөө, барилга байшин болгож хадгалдаггүй. Харин өөрийн ардын урлагаа ой ухаандаа амнаас ам дамжуулан үеэс үед үр удамдаа уламжлуулж ирсэн онцлогтой. Тийм үнэт өвийн нэг нь уртын дуу билээ. Уртын дууны ая нь аргадаж, үг нь зэмлэдэг гэсэн үг байдаг. Эндээс үзвэл уртын дууны ая шүлэг хоёр арга билэгийн нэгдэл тул хүнийг ухааруулах, ёс заншлаа хадгалах, хүмүүншихэд чухал ач холбогдолтой болно.
- Уртын дуу сонирхон суралцагчдын тоо цөөрч байгаатай холбогдуулан ардын дууны үг, ном бүхий эмхэтгэлийг хэвлэн гаргах, нутгийн зарим хувилбарын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах хэрэгтэй байна. Энэ нь ардын урлагийн өв санг уламжлуулах чухал ажил хэмээн сэтгэнэ.
- Уртын дууны ая дууны шүлгийн үе уртасгалд уртын дуучны ур чадвар хөгжмийн сэтгэлгээгээр, амьсгааны урлаг нэгдэн нийлдэг байна. Тиймээс уртын дууны сургалтад аялгууг дуулах, дууны шүлгийн үе өргөлтийг монгол хэлний авиан зүйн зөв дуудлагын дагуу баялаг өнгө үүсгэж, уртасган дуулах, дуулах ур зүй чадварыг улам хөгжүүлж байх асуудлыг анхаарах нь чухалтай байна.

Ашигласан материал

- Батмөнх, С. (2016). Ардын дуундаа жаргахын учир. Улаанбаатар
- Батболд, Б. (2011). Уртын дууны үгийн хувьслын асуудалд. Монголын соёл урлаг судлал. №14. Улаанбаатар
- Дэлгэр, Ц. (2011). XX зууны Монгол уртын дууны тухайд. Монголын соёл урлаг судлал. №13. Улаанбаатар
- Дугаржав, М. (1934). Үндэсний дуу хөгжмийг хэрхэн мандуулах тухай. Үндэсний соёлын зам сэтгүүл. 1934, №1. Улаанбаатар
- Ринчинсамбуу, Г. (1959). Монгол ардын дууны төрөл зүйл. Улаанбаатар
- Чулуунцэцэг, Ж. (2011). Монгол үндэстний найрал хөгжим, арга билгийн шүтэлцээ. Монголын соёл урлаг судлал. №13. Улаанбаатар
- Оюунбадрах, Б. (2013). Монголын хөгжмийн урлагийн гурван ай. Монголын соёл урлаг судлал. Эрдэм шинжилгээний бичиг. №16. Улаанбаатар
- Бадраа, Ж. (2008). Уртын дууг уламжлахад анхааръя. Монголын хөгжим судлалын дээж бичиг. Улаанбаатар
- Дорждагва, М. (эмхэтгэсэн). (2013). Монгол уртын дуу, түүнийг өвлөгчид. /дуу бичлэгийн хамт/ Улаанбаатар